

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМГИЙН ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗӨВЛӨЛ ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН
ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС
БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН
АУДИТЫН КОД: ГСА-2024/20-6-ШТА-ГА

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа, Утас: 70543156,
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр, Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Анхтуяа, Утас: 70543179
Цахим хаяг: Ankhtuyab@audit.gov.mn
Аудитор: Г.Ариунцэцэг, Утас: 70543179
Цахим хаяг: Ariuntsetsegg@audit.gov.mn

Говьсүмбэр аймаг

2024

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер
Г.Наранбаяр

Ахлах аудитор
Б.Анхтуяа

Аудитор
Г.Ариунцэцэг

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70543179 дугаарын утсаар
харилцана уу.

ХАЯГ:
Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 205 тоот

2024 оны 10 дугаар сар

ТОВЧИЛСОН ҮГС 3

Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлэх арга хэмжээг аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан боловч нийгмийн бүх талыг хамраагүй, хүртээмжгүй байна. 8

1.1 Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй арга хэмжээ нийгмийн бүх талыг хамарсан, хүртээмжтэй байдлыг хангаж чадахгүй байна. 8

1.2 Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь хүний нөөцийн дутагдалтай, мэдээллийн удирдлагын нэгдсэн систем байхгүйгээс хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй байна. 9

Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв хүртээмжтэй боловч оновчтой төлөвлөж хуваарилаагүйгээс байгууллагын урсгал зардлыг нөхөх зорилгоор зориулалт бусаар зарцуулсан байна. 13

2.1. Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилт хүрэлцээтэй байна. 13

2.2. Байгууллага хэвийн үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай урсгал зардлын төсвийг бодитой батлуулж чадаагүйгээс хүүхэд хамгаалалд төлөвлөсөн санхүүжилтбусаар зарцуулсан байна.14

Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилтийг үнэлэх аргачлал байхгүй, үр дүн, үр нөлөөг дүгнээгүй байна. 17

3.1 Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлт, аргачлал байхгүй байна. 17

3.2. Хүүхэд хамгааллын талаар салбар бүрт хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний үр дүн, үр нөлөөг тооцоогүй байна. 20

3.3 Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа эерэг үр дүнг үзүүлээгүй байна. 23

Дүгнэлт

Зөвлөмж

Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлан баталгаажуулах тушаал

Тайлангийн хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГС

БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ГХУСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ДЗОУБ	Дэлхийн зөн олон улсын байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НБХ	Нийгмийн бодлогын хэлтэс
ОБГ	Онцгой байдлын газар
ОНТ	Орон нутгийн төсөв
ОУБ	Олон улсын байгууллага
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
УТ	Улсын төсөв
ХГБХХЕГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар
ХГБХХГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХЭЗХ	Хууль, эрх зүйн хэлтэс
ХШҮХ	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЦХ	Цагдаагийн хэлтэс
ШТГ	Шүүхийн тамгын газар
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл,
бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2023 оны 08 дугаар тогтоол, МҮЕА-ын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162 дугаар тушаалыг үндэслэн болгон гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт бий болсон үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан ҮАГ, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ. Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

1. Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, төлөвлөлтийн тогтолцоо оновчтой эсэх
2. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхдэд ээлтэй байж чадсан эсэх
3. Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт үр дүнтэй эсэх

Аудитын хамарсан
хүрээ:

Аудитад Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд хүүхэд хамгааллын чиглэлээр оролцдог аймгийн ХГБХХГ, түр хамгаалах байр, Хүүхдийн төлөө зөвлөл, ХЭЗХ, аймгийн ИТХ-ын ГХУСЗ, аймгийн ЗДТГ-ын НБХ, сумдын хамтарсан багууд, Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын газар, БШУГ, ЕБС, Политехник коллежийн дотуур байр, хүүхэд хамгааллын баг, ЭМГ зэрэг байгууллагуудын 2019-2023 оны баримт материал, тайлан, үйл ажиллагааг хамруулав.

Аудитад дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашиглав.

Аудитын арга зүй:

- Хүүхдийн эрхийн тухай конвенц
- Монгол Улсын Үндсэн хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хүүхдийн төлөө зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл
- ХНХС, ХЗДХС-ын хамтарсан 2017 оны А/120, А/178 дугаар тушаалаар батлагдсан “Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”, “Хүүхэд хамгааллын үйлчилгээний багц маягт”
- ХНХС, ХЗДХС, ЭМС-ын хамтарсан 2017 оны А/173, А/251, А/3801 дугаар тушаалаар батлагдсан “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”, “Хамтарсан багийн үйлчилгээнд хэрэглэх багц маягт”, “Нууцын гэрээ”
- ХНХС-ын 2017 оны А/121 дүгээр тушаалаар батлагдсан “ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж, дүгнэх журам”

Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:

Хүндрэл бэрхшээл:

- ГБХЗХГ-ын даргын 2018 оны А/236 дугаар тушаалаар батлагдсан “Хамтарсан багийн үйлчилгээ, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”
- Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам”
- ХНХС-ын 2020 оны А/148 тоот тушаалаар батлагдсан “Тэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам”
- ГБХЗХГ-ын даргын 2020 оны 240 дүгээр тушаалаар батлагдсан “Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн элч, Хүүхдийн эрхийн ажилтны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх аргачлал”
- ХНХС-ын 2021 оны А/218 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”
- БШУС-ын 2022 оны “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”
- Түр хамгаалах байр, ЕБС-ийн сурагчдын дотуур байрны ерөнхий шаардлага, стандартууд
- Бусад холбогдох шийдвэрүүд

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Анхтуяа, аудитор Г.Ариунцэцэг нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын нээлтийг 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулж, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрөөс 10 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 10 дугаар сарын 22-ны дотор боловсруулан, тайланг дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хүргүүлээ.

Аудитыг гүйцэтгэхэд хуулийн мэдлэг бүхий мэргэшсэн албан хаагч дутагдалтай байгаа хэдий ч орон тооны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан эрх зүйч-аудитор ажиллуулах боломжгүй байна. Гүйцэтгэлийн аудитыг санхүүгийн мэргэжлийн аудиторууд гүйцэтгэж байгаа нь ойлголтын зөрүүтэй асуудал үүсэх, хууль эрхзүйн мэдлэг дутах зэрэг хүндрэл бэрхшээл үүсэж байна. Хүүхэд хамгааллын салбарын ажилтнууд тогтвор суурьшилгүй, олон удаа солигдсоноос шалтгаалан архиваас баримт материал олдохгүй, 2019-2023 онуудад хийгдсэн ажлыг тайлбарлаж мэдэхгүй байсан, статистик тоон мэдээллүүдийг баталгаажуулаагүй, зөрүүтэй зэрэг хүндрэл бэрхшээл тулгарч байна. Аудитад хамрагдаж буй байгууллагуудад нийтлэг байдлаар хүүхэд хамгааллын үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг архивлаагүй, архивд хүлээлгэн өгөөгүй байна.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Говьсүмбэр аймгийг хөгжүүлэх 2021, 2022, 2023 оны жилийн төлөвлөгөө, 2019-2020 онд Зорилтот бүлэгт чиглэсэн дэд хөтөлбөрт Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлэх арга хэмжээг тус тус тусган хэрэгжүүлсэн байна.

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн дуудлага 2019 онтой харьцуулахад жил бүр 4-21 хүртэл тоогоор өссөн ба 2023 онд 59.5%-аар өсөж 51 дуудлага мэдээлэл бүртгэгдсэн байна.

Нийт дуудлагын 70-96%-ийг хүүхэд хамгаалалтай холбоотой, үлдсэн 4-30%-ийг зөвлөгөө хүссэн дуудлага эзэлж байна.

2019-2023 онуудад түр хамгаалах байраар 95 хүүхэд аюулгүй байдлын хамгаалалт, хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан байна. Хүүхэд хөгжил, хамгааллын үйлчилгээнд улсын төсвөөс батлагдсан төсөв 2019-2022 онд 49.4 сая, 2023 онд 49.9%-аар өсөж 74.1 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэл 100%-тай байна.

Аймгийн хэмжээнд 2019-2023 оны хүүхдийн статистик тоон үзүүлэлт дараах байдалтай байна.

Огноо	0-18 насны хүүхдийн тоо	Бүтэн өнчин хүүхдийн тоо	Хагас өнчин хүүхдийн тоо	Эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн тоо	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	Хөдөлмөр эрхлэгч хүүхдийн тоо
2019	6894	20	159	141	69	7
2020	6954	15	155	235	70	2
2021		19	170	236		3
2022	7400	24	171	254	80	-
2023	7404	25	147	352	88	-

Дүрслэл товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээллийн сангууд	10
Дүрслэл 2	ГБХЗХГ-ын орон тоо, бүтэц /2019-2023/	11
Дүрслэл 3	Хуульд заасан 6 чиглэлээр хариу үйлчилгээ үзүүлэхэд зарцуулсан зардлын ангилал	15
Дүрслэл 4	Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд ирсэн дуудлагын тоо	22
Дүрслэл 5	Хүүхэд хамгаалалтай холбоотой дуудлагыг хүчирхийллийн хэлбэрээр нь ангилж харуулсан байдал	22
Дүрслэл 6	Сумдын хамтарсан багуудын туршлага, сайн жишээ	25
Дүрслэл 7	Аймгийн хэмжээнд гэмт хэрэгт холбогдсон болон гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоо	26

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Бодлогын баримт бичигт тусгагдсан хүүхэд хамгаалалтай холбоотой зорилт, арга хэмжээ	8
Хүснэгт 2	Хүүхэд хамгааллын зардлын төсвийн төсөл, батлагдсан төсөв	12
Хүснэгт 3	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын зарцуулалт	12
Хүснэгт 4	Хүүхэд хамгааллын батлагдсан төсөв 2022-2023 он	13
Хүснэгт 5	Хүүхэд хамгааллын зардлын зарцуулалт	13
Хүснэгт 6	ДЗОУБ-аас санхүүжүүлсэн дэмжлэгийн задаргаа	14
Хүснэгт 7	2019-2023 онд эрсдэлт нөхцөл дэх хүүхдэд зарцуулсан төсвийн зарцуулалт	15
Хүснэгт 8	2019-2023 оны батлагдсан төсөв, зарцуулалт	16
Хүснэгт 9	Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн зөрчил шийдвэрлэлт	17
Хүснэгт 10	Эрүүл мэндийн салбарын 2019-2023 оны тоон мэдээлэл	20
Хүснэгт 11	Гамшиг, осол аюулт үзэгдэлд өртсөн хүүхдийн тоо, мэдээлэл /2019-2023 он/	21
Хүснэгт 12	Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд ирсэн дуудлагыг статистик тоон мэдээтэй харьцуулсан харьцуулалт	28
Хүснэгт 13	Аймгийн ЦХ, ШТГ-аас ирүүлсэн тоон үзүүлэлтийг аймгийн ХГБХХГ-ын гаргасан тоон үзүүлэлттэй харьцуулсан байдал	28
Хүснэгт 14	ХГБХХЕГ-аас ирүүлсэн эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн тоог аймгийн ХГБХХГ-ын гаргасан тоон үзүүлэлттэй харьцуулсан байдал	28

Зураг товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Аймгийн ХГБХХГ-ын дэргэдэх Түр хамгаалах байрны зураг	25
Зураг 2	Хамтарсан багуудтай уулзсан уулзалтын үеийн зураг	26

БҮЛЭГ 1

Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлэх арга хэмжээг аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан боловч нийгмийн бүх талыг хамраагүй, хүртээмжгүй байна.

1.1 Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй арга хэмжээ нийгмийн бүх талыг хамарсан, хүртээмжтэй байдлыг хангаж чадахгүй байна.

1.1.4 Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлэх арга хэмжээг аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын I үе шат (2021-2030), Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, “Монгол Улсын хөгжлийн 2021-2023 оны төлөвлөгөө”-ний “Хүний хөгжил” хөтөлбөрийн хүрээнд аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийг баталсан байна. Тус бодлогын баримт бичигт хүүхэд хамгаалалтай холбоотой дараах зорилт, арга хэмжээг төлөвлөсөн байна. Үүнд:



Хүснэгт №1. Бодлогын баримт бичигт тусгагдсан хүүхэд хамгаалалтай холбоотой зорилт, арга хэмжээ

Бодлогын баримт бичгийн нэр	Хүүхэд хамгаалалтай холбоотой			
	Дэвшүүлсэн зорилт	Арга хэмжээ	Санхүүжилтийн эх үүсвэр	Мөнгөн дүн /сая төгрөг /
Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	1	3	УТ, ОНТ, ОУБ	82.5
Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2	6	УТ, ОНТ	63.0
Говьсүмбэр аймгийг хөгжүүлэх 2021 оны жилийн төлөвлөгөө	2	8	ОНТ	20.0
Говьсүмбэр аймгийг хөгжүүлэх 2022 оны жилийн төлөвлөгөө	2	9	ОНТ	11.0
Говьсүмбэр аймгийг хөгжүүлэх 2023 оны жилийн төлөвлөгөө	2	5	УТ, ОНТ	32.0
Зорилтот бүлэгт чиглэсэн дэд хөтөлбөр /2019 /	1	2	ОНТ	0.4
Нийт	10	33		208.9

Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн бодлогын баримт бичгийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан дахь хамаарал бүхий зорилт, арга хэмжээний нэгтгэл /аудиторын боловсруулсан ажлын баримт/

Хүснэгтээс харахад Сүүлийн 5 жилд /2019-2023 онуудад/ нийт 10 зорилт, 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгийн эх үүсвэрээс 208.9 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна. Зорилтот бүлэгт чиглэсэн дэд хөтөлбөр 2019 онд хэрэгжээд дууссан бол Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт 2021 онд 92.1%, 2022 онд 93.3%, 2023 онд 100%-тай гэж дүгнэсэн байна.

Дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан зорилтын хүрээнд жил бүрийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ нь 1 ажлыг давтан давтан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй арга хэмжээ нийгмийн бүх талыг хамарсан, хүртээмжтэй байдлыг хангаж чадахгүй байна.

1.1.6 Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын чиглэлээр хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж батлаагүй байна.

Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын чиглэлээр тусгайлан боловсруулж баталсан хөтөлбөр, төлөвлөгөө байхгүй байна. Харин аймгийн Засаг даргын 2016 оны 71 дүгээр захирамжаар 2016-2020 онд хэрэгжүүлэхээр “Зорилтот бүлэгт чиглэсэн дэд хөтөлбөр”, 2021 оноос жендерийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээнд хүүхэд хамгааллын чиглэлээр тусгасан арга хэмжээ байхгүй, хүүхэд хөгжил оролцооны чиглэлээр 2 арга хэмжээ тусгаж баталсан байна.

1.2 Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь хүний нөөцийн дутагдалтай, мэдээллийн удирдлагын нэгдсэн систем байхгүйгээс хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй байна.

1.2.2 Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн тусгасан эсэхэд ХГБХХЕГ-аас хяналт тавьж ажиллаагүйгээс зарим чиг үүргийг орхигдуулсан байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын үйл ажиллагаа, чиг үүрэг нь Хүүхэд хамгааллын тухай хуульд 7, Хүүхдийн эрхийн тухай хуульд 9 заалтаар тус тус тодорхойлогдсон байна.

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын хуулиар хүлээсэн чиг үүргүүдийг 2019-2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдтэй тулган баталгаажууллаа. Тулган баталгаажуулалтын хүрээнд дараах нөхцөл байдалтай байна. Үүнд:

1. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2¹, 18.2.4², 18.2.5³, 18.2.6⁴, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1⁵, 15.1.2⁶, 15.1.3⁷, 15.1.4⁸, 15.1.5⁹, 15.1.6¹⁰, 15.1.7¹¹-д заасан 11 чиг үүргийг жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэвшсэн
2. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1-д “*Нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаарх мэдээлэл, судалгаанд нэгдсэн дүгнэлт хийж, цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлох*”, 18.2.3-д “*Хүүхдийн эрхийн тухай болон энэ хуулийн хэрэгжилтэд гурван жил тутамд нэгээс доошгүй удаа анхан шатны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх*”, 18.2.7-д “*Гэр бүлээсээ дайжсан, эсхүл эцэг, эх, асран хамгаалагчийн халамж анхаарал, хараа хяналтаас гадуур байгаа хүүхдийг бүртгэх, судалгаанд авах, гэр бүлд нэгтгэх ажлыг орон нутгийн Цагдаагийн байгууллагатай хамтран гүйцэтгэх*” гэсэн 3 чиг үүргийг тусгаагүй
3. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д “*Хүүхдийн эрхийн чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах*” гэсэн 1 чиг үүргийг тусгаагүй

ХГБХХЕГ-аас аймгийн ХГБХХГ-ын хуульд заасан чиг үүргийг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгасан эсэхэд хяналт тавиагүй, зарим чиг үүргийг орхигдуулсантай холбоотойгоор хуулиар хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

¹ 18.2.2.төрийн байгууллага, хуулийн этгээд, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагын хүүхдийн асуудал хариуцсан ажилтан, алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх

² 18.2.4.нийгмийн ажилтан, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэгчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах

³ 18.2.5.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаархи мэдээллийн сан бүрдүүлж үйл ажиллагаандаа ашиглах, бүртгэл, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн халамж, хамгаалал үйлчилгээний талаар бүртгэл хөтөлж, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

⁴ 18.2.6.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэд харагчийг сайн дурын болон хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр албадан сургалтад хамруулах ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран зохион байгуулах

⁵ 15.1.1.тухайн нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх бодлого, төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах

⁶ 15.1.2.тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагад хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих

⁷ 15.1.3.эрх нь зөрчигдсөн хүүхдийг дагнасан үйлчилгээгээр хангаж, хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, асрамжийн зэрэг шаардлагатай үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах

⁸ 15.1.4.хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн ажлыг гэр бүл, олон нийтийн оролцоо, дэмжлэгт тулгуурлан холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах

⁹ 15.1.5.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн тухайн шатны байгууллага, ажилтан нь хүүхэд, гэр бүл, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг зөвлөгөө, мэдээллээр хангах, шаардлагатай бол сургалт зохион байгуулах, нийгмийн ажилтны үйл ажиллагааг дэмжиж, арга зүйн удирдлагаар хангах

¹⁰ 15.1.6.энэ хуулийн 14.2-г заасан журмын дагуу анхан шатны байгууллага, ажилтан, хамтран ажиллаж байгаа хуулийн этгээдээс мэдээ тайлан авч, цаашид авах шаардлагатай арга хэмжээний талаар зөвлөмж өгөх, хэрэгжилтийг хянах, холбогдох мэдээллийг нэгтгэн төв байгууллагад хүргүүлэх

¹¹ 15.1.7.хүүхэд гишүүнчлэлтэй болон эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагаа хэрэгжүүлэх хуулийн этгээдийн үйл ажиллагааг төрөөс дэмжин, байр, танхимаар хангах

Иймд Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүлээсэн чиг үүргийг жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.2.5 Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мэдээллийн удирдлагын нэгдсэн систем байхгүй байна.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын чиглэлээр 3 мэдээллийн сан бүртгэлтэй байна. Тус мэдээллийн сангууд нь дараах чиглэлтэй байна. Үүнд:

Дүрслэл №1

1.Хүүхдийн тусламжийн 108 утас

Зорилтот болон зорилтот бус дуудлагыг бүртгэж, утсаар зөвлөгөө өгөх, холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн эрхийн мэдээлэл зөвлөгөө өгөх



2.Эйбл программ

- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн мэдээллийн сан /Хүүхдийн эрсдэл, нөхцөл байдал, гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх/
- Уралдаанч хүүхдийн мэдээллийн сан /Уралдааны мэдээлэл, уяачид, уралдаанч хүүхдийн бүртгэл/
- Хүүхэд харах үйлчилгээнд бүртгэлтэй хүүхдийн мэдээллийн сан /Хүүхэд харагч, хүүхдийн бүртгэл/

Able программ
-Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн мэдээллийн сан
-Уралдаанч хүүхдийн мэдээллийн сан
-Хүүхэд харах үйлчилгээнд бүртгэлтэй хүүхдийн мэдээллийн сан

Etuslamj
/Түр хамгаалах байраар үйлчлүүлсэн хүүхдийн мэдээллийн сан

3. etuslamj.mn -Түр хамгаалах байраар үйлчлүүлсэн хүүхдийн бүртгэл

Хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд ашиглаж буй мэдээллийн сангуудын ашиглалтыг шалгахад дараах байдалтай байна.

- ✚ Аймгийн ХГБХХГ, хамтарсан багийн нарийн бичиг хүүхдийн тусламжийн 108 утасны программыг ашиглаж байгаа бөгөөд үйл ажиллагаа хэвийн
- ✚ Etuslamj.mn программыг 2021 онд ашиглалтад оруулсан боловч 2023 оноос хойш ашиглахаа больсон
- ✚ Эйбл программд – 3 чиглэлээр мэдээллийн сан үүсгэж байгаа бөгөөд 2 нь мэдээлэл оруулахад алдаа гарч байна. Тухайлбал:
 - Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн мэдээллийн санг ашиглаж байгаа боловч 2019 онд 12, 2020 онд 196, 2021 онд 21 хүүхдийн бүртгэл оруулсан бөгөөд хүүхдийн мэдээлэл оруулахад алдаа гардаг гэсэн тайлбарыг өгсөн. 2022-2023 онд хүүхэд бүрээр эрсдэлийн, нөхцөл байдлын, гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээг оруулах ёстой боловч хүний нөөцийн дутагдалтай байдал, сул орон тоо нөхөгдөхгүй байгаа гэсэн шалтгаанаар огт мэдээлэл оруулаагүй байна.
 - Уралдаанч хүүхдийн мэдээллийн сан ашиглаж байгаа боловч мэдээлэл оруулах явцад мөн алдаа гардаг асуудал үүсдэг байна.
- ✚ Хүүхэд харах үйлчилгээнд бүртгэлтэй хүүхдийн мэдээллийн сангийн ашиглалт хэвийн байна.

Дээрх мэдээллийн сангууд хоорондоо мэдээлэл солилцдоггүй, бодит цагийн үйл ажиллагааг гүйцэтгэх боломжгүй, уг системүүдийн хөгжүүлэлт хангалтгүй, хүний нөөцийн дутагдалтай байдлаас шалтгаалан мэдээллийг бүрэн оруулах нөхцөл боломж бүрдээгүй байна. Мөн хамтарсан багийн гишүүдэд ашиглах мэдээллийн нэгдсэн систем байхгүй байна.

Хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд ашиглаж буй мэдээллийн сангууд нь зөвхөн мэдээллийн бааз архив үүсгэх зориулалтаар л ашиглагдаж байгаа боловч мэдээллийн аюулгүй байдал хангагдаагүй,мэдээлэл устаж үгүй болох, кибер халдлагад өртөх зэрэг эрсдэлтэй байна.

Аймгийн ХГБХХГ нь хүүхэд хамгааллын талаар статистик тоон үзүүлэлтийг албан ёсоор баталгаажуулаагүй, ХГБХХЕГ-т цахим хэлбэрээр хүргүүлж нэгтгүүлсэн байна. Хариуцсан мэргэжилтэн “ХГБХХЕГ нь статистик тоон үзүүлэлтийг цаасаар авах шаардлагагүй” гэсэн тул цахимаар хүргүүлдэг тухай тайлбар өгсөн. Дээрх тоон үзүүлэлтүүд нь ХГБХХЕГ-аас ирүүлсэн тоон үзүүлэлтээс зөрүүтэй байгаа нь цахимаар нэгтгэсэн бөгөөд баталгаажуулсан статистик мэдээ байхгүй тул тулган баталгаажуулах боломжгүй байна. Батлагдсан маягтаар статистик мэдээг гаргаж байгаа боловч тоон мэдээлэл давхардсан үзүүлэлтүүд их байна.

Иймд статистик тоон үзүүлэлт, мэдээ тайланг үнэн зөв гаргах, үзүүлэлт бүрээр дүн шинжилгээ хийж эрсдэлийг тодорхойлон, асуудлыг эрэмбэлж, дарааллын дагуу шийдвэрлэх талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

УАГ-т уламжлах санал: Хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн сан бий болгох, одоо ашиглагдаж буй мэдээллийн сангийн ашиглалтыг сайжруулах, тоон үзүүлэлтийн давхардлыг арилгаж бодит тоон үзүүлэлтэд нийцүүлэн статистик үзүүлэлт тооцох аргачлалыг шинэчилж, статистик мэдээний цахим системтэй болох

1.2.6 Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт орон тоо хүрэлцээтэй батлагдсан боловч хүний нөөц дутагдалтай, тогтвор суурьшилгүй ажиллаж байна.

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын бүтэц, орон тоог аймгийн Засаг даргын 2020 оны А/47, ГБХЗХГ-ын 2022 оны А/56 дугаар тушаалаар тус тус баталсан байна.

2020 онд хүүхэд хамгааллын чиглэлээр 5 орон тоотой байсан бол 2022 онд 7 орон тоо батлагдаж орон тоо 2-оор нэмэгдсэн байна.

Дүрслэл №2 ГБХЗХГ-ын орон тоо, бүтэц /2019-2023/

Аймгийн Засаг даргын 2020 оны А/47 дугаар захирамж	• Гэр бүлийн хөгжлийн алба • Сэтгэл зүйч-1 • Түр хамгаалах байрны ажилтан-1 • Хүүхдийн хөгжил, хамгааллын алба • Хүүхдийн эрх, хамгаалал хариуцсан мэргэжилтэн, Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан / Хүүхдийн эрхийн улсын байцаагч /-1 • Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн-1 • Нийгмийн ажилтан-1	2019-2023 онд хүүхдийн эрхийн улсын байцаагч 2, хүүхдийн эрх хамгааллын мэргэжилтэн 1, нийгмийн ажилтан 2 удаа тус тус солигдсон байна.
		2020-2023 онд аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд сул орон тооны зарыг 9 удаа хүргүүлж зарлуулсан байна. 2021 онд 2, 2023 онд 3 орон тоо нөхсөн байна. 2024 оны байдлаар хүүхдийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, хүүхдийн эрх хамгааллын мэргэжилтний орон тоо сул, нөхөгдөөгүй байна.
ГБХЗХГ-ын 2022 оны А/56 дугаар тушаал	• Хүүхдийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн-1 • Хүүхдийн эрхийн улсын байцаагч-1 • Хүүхдийн эрх, хамгаалал хариуцсан мэргэжилтэн-1 • Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн-1 • Нийгмийн ажилтан /зохицуулагч/-1 • Үйлчилгээний ажилтан-2	

Эх сурвалж: Аймгийн Засаг дарга, ГБХЗХГ-ын шийдвэр

Тус газарт төрийн захиргааны албан тушаалд 12 албан хаагч ажиллахаас 5 албан хаагч ажиллаж байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад орон тоо хүрэлцээтэй боловч хүний нөөц дутагдалтай байна. Хүний нөөцийн дутагдалтай байдал, албан хаагч тогтвор суурьшилгүй ажиллахад цалин хөлсний нөхцөл тааруу, орон нутагт төрийн албаны нөөцөд бүртгэлтэй шаардлага хангасан албан хаагч байхгүйгээс сул орон тоо нөхөгдөхгүй байгаа, төрийн албаны ерөнхий шалгалтад ороод тэнцдэггүй, дахин шалгалт өгөхөөс шантардаг, мөн орон тоо дутуугаас нэг

ажилтанд олон ажлыг давхардуулан хариуцуулж ажлын ачааллыг нэмэгдүүлдэг зэрэг нөхцөл байдал нөлөөлж байна.

Мэргэжлийн хүнийг тогтвортой ажиллуулах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, давхар ажлын ачаалал өгөхгүй байх, хүүхэд хамгааллын ажилтны эрүүл мэнд, сэтгэл зүйг хамгаалах, урамшуулж дэмжих, нийгмийн хамгааллыг нь сайжруулах шаардлагатай байна.

Жишээ 1: Аймгийн ХГБХХГ-ын сэтгэл зүйчийн цалин хөлс, ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйчийн цалин хөлснөөс бага байгаа нь орон тоо нөхөгдөхгүй байх шалтгаан болж байна.

Аудитаар тус газарт сэтгэл зүйчийн албан тушаалд эрх зүйч мэргэжилтэй мэргэжлийн бус хүн ажиллаж байгаа зөрчил илэрсэн байна. Энэ нь ГБХЗХГ-ын даргын 2020 оны А/14 дүгээр тушаалаар батлагдсан “Сэтгэл зүйч”-ийн албан тушаалын тодорхойлолтын тусгай шаардлагатай нийцээгүй байна.

Иймд сэтгэл зүйчийн орон тоонд албан тушаалын тодорхойлолтод заасан шалгуурыг хангасан ажилтан авч ажиллуулах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

ҮАГ-т уламжлах санал:

1. Салбарын хэмжээнд хүний нөөцийн болон нийгмийн хамгааллын бодлогыг уялдуулан боловсруулж, орон нутгийн байгууллагуудын бүтэц оновчтой боловсруулах, төрийн захиргааны албан тушаалын сул орон тоо нөхөгдөхгүй байгаа асуудалд дүн шинжилгээ хийж, зарим орон тоог төрийн үйлчилгээ болгож шийдвэрлэх боломжтой эсэхийг судлах

БҮЛЭГ 2

Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв хүртээмжтэй боловч оновчтой төлөвлөж хуваарилаагүйгээс байгууллагын урсгал зардлыг нөхөх зорилгоор зориулалт бусаар зарцуулсан байна.

2.1. Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилт хүрэлцээтэй байна.

2.1.1. Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг 2023 оноос зориулалт, арга хэмжээ бүрээр төлөвлөж эхэлсэн байна.

Аймгийн ХГБХХГ нь 2018-2022 онд хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв, хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөж, ХГБХХЕГ-т хүргүүлсэн байна.

Хүснэгт: №2 Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын төсвийн төсөл, батлагдсан төсөв

Зардлын нэр	2019 он		2020 он		2021 он		2022 он		2023 он	
	Санал	Батлагдсан	Санал	Батлагдсан	Санал	Батлагдсан	Санал	Батлагдсан	Санал	Батлагдсан
Хүүхэд хамгааллын зардал	-	48.8	48.6	49.4	54.5	49.4	49.4			
Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	-	-	-	-	-	-	-	22.2	11.8	12.6
Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардал	-	-	-	-	-	-	-	30.0	16.7	60.7
Эрсдлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх зардал	-	-	-	-	-	-	-	1.2	2.0	0.8
Нийт дүн	0.0	48.8	48.6	49.4	54.5	49.4	49.4	53.4	30.5	74.1

Эх сурвалж: Аудиторын хийсэн тулган баталгаажуулалт

Хүснэгтээс харахад аймгийн ХГБХХГ-с 2019 оны төсвийн төсөлд хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын төсвийг тусад нь төлөвлөж хүргүүлээгүй боловч ерөнхий газраас нь системийн хэмжээнд санхүүжилт олгосон бөгөөд 2020 оноос хойш зардлыг төлөвлөдөг болсон байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын төсвийг 2019-2021 он хүртэл нэг зардлын ангиллаар тогтмол нэг дүнгээр батлан ирүүлж байсан бол 2022 оноос хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг зориулалт, арга хэмжээ бүрээр тусад нь буюу 3 чиглэлээр хуваарилдаг болсноор 2023 оноос төсвийн төслийн саналыг зориулалт, арга хэмжээгээр тусад нь төлөвлөж хүргүүлсэн байна.

2023 оны төсвийн төсөлд хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг нийт дүнгээр 30.5 сая төгрөгөөр төлөвлөж санал хүргүүлсэн боловч 74.1 сая төгрөг батлагдаж, төсвийн төсөлд хүргүүлсэн саналаас 43.6 төгрөгийн төсөв илүү батлагдаж ирсэн байна. Энэ нь улсын хэмжээнд хүүхэд хамгааллын зардлыг нэмэгдүүлж баталснаас шалтгаалсан байна.

Цаашид ХГБХХЕГ-аас хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг аймгийн ХГБХХГ-аас хүргүүлсэн төсвийн төслийн саналыг харгалзан оновчтой хуваарилах шаардлага үүссэн байна.

2.1.2. Хүүхэд хамгааллын төсвийн 57.4% нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулахад зарцуулсан байна.

Аймгийн ХГБХХГ-ын хүүхэд хамгааллын төсөвт 2019-2023 онд нийт 275.2 сая төгрөг батлагдсанаас Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд нийт төсвийн 57.4% буюу 157.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт: №3 Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын зарцуулалт

Арга хэмжээний нэр	2019 он	2020 он	2021 он	2022 он	/сая.төгрөгөөр/	
					2023 он	Нийт
Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	32.1	37.5	31.2	22.2	34.9	157.9

Эх сурвалж: Аудиторын тулган баталгаажуулалт

Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын 157.9 сая төгрөгийн зарцуулалтаас 11.1% буюу 17.6 сая төгрөгийг хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулах арга хэмжээнд зарцуулсан байна.



2.1.3 Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай зардлыг 2022 оноос зориулалт, арга хэмжээ бүрээр хуваарилж эхэлсэн байна.

2019-2021 онд хүүхэд хамгааллын төсвийг зориулалт, арга хэмжээ бүрээр хуваарилаагүй байна. 2022-2023 онд хүүхэд хамгааллын төсөв нийт 127.5 сая төгрөг батлагдсанаас урьдчилан сэргийлэх зардалд 34.9 сая, хамгаалах нөхөн сэргээх зардалд 90.7 сая, эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх зардалд 2.0 сая төгрөг тус тус хуваарилагдсан байна.

Хүснэгт №4 Хүүхэд хамгааллын зардлын батлагдсан төсөв 2022-2023 он

Арга хэмжээний нэр	2022 он	2023 он	Нийт
80238-Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	22.3	12.6	34.9
80237-Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардал	30.0	60.7	90.7
80236-Эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх зардал	1.2	0.8	2.0
Нийт	53.4	74.1	127.5

Эх сурвалж: Аудиторын тулган баталгаажуулалт

Хүснэгтээс харахад хүүхэд хамгааллын төсвийг өмнөх онуудад нийтлэг байдлаар 1 зардлын ангиллаар баталж хуваарилдаг байсан бол 2022 оноос хүүхэд хамгааллын төсвийг урьдчилан сэргийлэх, хамгаалах нөхөн сэргээх, эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх гэсэн 3 зардалд ангилан хуваарилдаг болсон нь хүүхэд хамгааллын үйлчилгээнд зарцуулах төсөв илүү нээлттэй тодорхой болсон байна. Гэсэн хэдий ч 3 зардлын ангиллаар хуваарилахдаа ямар тооцоо судалгааг үндэслэж аль зардалд нь төсвийг хэрхэн хуваарилсан эсэх нь тодорхойгүй орон нутагт үйл ажиллагаа явуулж буй тухайн анхан шатны байгууллагаасаа санал аваагүй байна.

Тухайлбал: 2023 онд баталсан хүүхэд хамгааллын зардлын 74.1 сая төгрөгөөс 60.7 сая төгрөг буюу 82%-ийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардалд хуваарилжээ. 2023 онд өмнөх онтой харьцуулахад хүүхэд хамгааллын зардлын санхүүжилт 38.7%-иар нэмэгдэж батлагдсан боловч ямар үндэслэлээр нэмэгдсэн нь тодорхойгүй байна.

2.2. Байгууллага хэвийн үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай урсгал зардлын төсвийг бодитой батлуулж чадаагүйгээс хүүхэд хамгаалалд төлөвлөсөн санхүүжилтбусаар зарцуулсан байна.

2.2.1 Хүүхэд хамгааллын чиглэлээр төлөвлөсөн санхүүжилтээс 60.8 сая төгрөгийг зориулалтын бус зардалд зарцуулсан байна.

Аймгийн ХГБХХГ нь 2019-2023 онд хүүхэд хамгааллын чиглэлээр улсын төсвөөс 274.0 сая төгрөгийн санхүүжилт авч, зарцуулсан байна.

Хүснэгт №5 Хүүхэд хамгааллын зардлын зарцуулалт

Зардлын нэр	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	Нийт
-------------	---------	---------	---------	---------	---------	------

Урьдчилан сэргийлэх зардал	48.0	49.4	49.0	22.3	12.6	181.2
Хамгаалах, нөхөн сэргээх зардал				30.0	60.6	90.6
Эрсдлийн болон НБҮ хийх				1.1	0.9	2.0
Нийт дүн	48.0	49.4	49.0	53.4	74.1	274.0

Эх сурвалж: Аудиторын тулган баталгаажуулалт

Хүснэгтээс харахад: 2022-2023 онд зардлын ангиллаар хуваарилж эхэлсэн бөгөөд 2022 онд өмнөх оноос 9%, 2023 онд 38.7%-иар тус тус нэмэгдсэн байна.

Аудитаар 2019-2023 оны хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийн зарцуулалтыг тулган баталгаажуулахад 60.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан дараах зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Гэрлэлтийн батламж гардуулах зардалд 2.6 сая,
- Үндсэн хөрөнгө бэлтгэх зардалд 8.5 сая,
- Албан хаагчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх зардал 0.5 сая
- Үндсэн үйл ажиллагааны тайлан, ном хэвлүүлэх зардалд 7.2 сая
- Аудитын төлбөрт 0.7 сая
- Багш, сурагчдын шагналын зардалд 16.1 сая
- Бусад зардалд 25.2 сая

Улсын төсвийн санхүүжилтээс 2019-2023 онд Түр хамгаалах байрны тогтмол зардалд 6.1 сая, урсгал зардалд 26.5 сая, нийт 32.6 сая төгрөг зарцуулсан бөгөөд түр хамгаалах байрны урсгал зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2¹², 19 дүгээр зүйлийн 19.1.5¹³-д Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1¹⁴, 6.6.2¹⁵, 16 дугаар зүйлийн 16.5.5¹⁶ дахь заалтыг зөрчсөн байна. Иймд аймгийн ХГБХХГ-т хуульд заасан чиг үүргийн хүрээнд түр хамгаалах байрны урсгал зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2019-2023 онд аймгийн ХГБХХГ-аас ХГБХХЕГ-т төсөв нэмэгдүүлэх, гүйлгэн зарцуулах хүсэлтийг албан бичгээр удаа дараа хүргүүлсэн боловч шийдвэрлэдэггүй, үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг төсвийн төсөлд хүргүүлсэн саналаас бууруулж баталдаг зэрэг нь хүүхэд хамгааллын зардлыг зориулалт бусаар зарцуулах нөхцөл байдал үүсэхэд хүргэж байна.

Аймгийн хэмжээнд 2019-2023 онд хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд орон нутгийн төсвөөс сумдын хамтарсан багийн үйл ажиллагааны зардалд 38.7 сая, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд аймгийн ГХУСЗ-өөс 54.4 сая төгрөгийг зарцуулсан бол ДЗОУБ-ын төсөл хөтөлбөрөөс 31.8 сая төгрөгийн хөрөнгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Иймд аймгийн ХГБХХГ-т хүүхэд хамгааллын зардалд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээнд үр ашигтай хуваарилж, зарцуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

2.2.2 Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтыг ил тод тайлагнасан байна.

Аймгийн ХГБХХГ нь хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтын тайлан, мэдээг НББ-ийн тухай хуулийн дагуу ХГБХХЕГ-т жил бүр хүргүүлж ажилласан байна. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтыг тухай бүр мэдээлсэн байна.

Хүүхэд хамгааллын талаар мэдээлэл, танилцуулга бэлтгэн байгууллагынхаа цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд мэдээлэл түгээн ил тод байдлыг хангаж ажилласан байна.

¹² Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардал, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх

¹³ тухайн шатны жилийн төсвийн төсөлд нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон зардлыг тусгаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах

¹⁴ Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

¹⁵ төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх

¹⁶ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

2.2.3 ДЗОУБ-аас хөрөнгийн ашиглалтад хяналт хэрэгжүүлсэн тайлан байхгүй байна.

2019-2023 онд аймгийн ХГБХХГ нь ДЗОУБ-аас 3.3-11.6 сая төгрөгийн 4 удаагийн нийт 31.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, хөрөнгийн дэмжлэг авч ажилласан байна.

Хүснэгт № 6 ДЗОУБ-аас санхүүжүүлсэн дэмжлэгийг дэлгэрэнгүй байдлаар харуулбал:

Огноо	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/	Хамтран ажилласан арга хэмжээний нэр	Үзүүлсэн дэмжлэг, туслалцаа
2019	11.6	Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөөний тохижилт	Тоног төхөөрөмж
2020	7.9	Түр хамгаалах байрны тохижилт	Үндсэн хөрөнгө
2022	9.0	Түр хамгаалах байрны тохижилт	Үндсэн хөрөнгө
2023	3.3	Эрсдэлд өртсөн хүүхдийн сэтгэхүй хөгжүүлэх хэрэглэгдэхүүн	Оёдлын машин, хатгамал, шигтгээ, сүлжмэл, гар урлалын зүйлс
Нийт	31.8		

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын 2019-2023 оны санхүүгийн баримтуудаас нэгтгэсэн ажлын баримт


Хүснэгтээс харахад: 2021 онд дэмжлэг аваагүй бөгөөд дэмжлэгээр ирсэн хөрөнгийг тухай бүр байгууллагын данс бүртгэлд тусгасан байна.

ДЗОУБ-аас санхүүгийн дэмжлэг үзүүлсэн арга хэмжээ, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.

2.2.4 Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлж байгаа боловч цогц байдлаар үйлчилгээ үзүүлсэн тоон мэдээлэл хангалтгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1¹⁷-д хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг 6 чиглэлээр үзүүлнэ гэж заасны дагуу аймгийн ХГБХХГ нь 2019-2023 онд хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 49.8 сая, шуурхай тусламжийн үйлчилгээнд 5.6 сая, нийт 55.4 сая төгрөг зарцуулсан байна.

Хуульд заасан 6 чиглэлээр хариу үйлчилгээ үзүүлэхэд зарцуулсан зардлыг ангилж харуулбал: Дүрслэл №3



Хүүхэд хамгааллын хариу арга хэмжээг дээрх 6 чиглэлээр үзүүлж байгаа бөгөөд “хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх, асрамж халамжид хүлээлгэн өгсний дараа хяналт, дэмжлэг үзүүлнэ” гэсэн энэ үйлчилгээ орхигдсон нь хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхойлсон бодлого шийдвэр байхгүй, хүний нөөцийн дутагдалтай байдал нөлөөлсөн байна.

Хүснэгт № 7 2019-2023 онд эрсдэлт нөхцөл дэх хүүхдэд зарцуулсан төсвийн зарцуулалт

Огноо	Эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн тоо	Арга хэмжээнд хамруулсан эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн		Зарцуулсан төсөв /сая.төгрөгөөр/	Арга хэмжээний нэр
		Тоо	Хувь		
2019	117	11	10	0.3	ХБ-тэй хүүхдүүдэд хүнсний материал
2020	235	160	68.0	1.5	Даатгал, хувцас
2021	254	254	100	25.3	Хувцас, бичиг хэргийн материал
2022	236	146	61.8	14.1	Хувцас
2023	352	26	7.3	4.5	Зуслангийн унаа, хоол

¹⁷ Эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих чиглэлээр дараахь хариу үйлчилгээ үзүүлнэ

Нийт	1194	597	50	45.7	
------	------	-----	----	------	--

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын 2019-2023 оны санхүүгийн баримтууд

2019-2023 онд жил бүрийн тодорхойлсон аймгийн хэмжээний эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн 10-100% буюу давхардсан тоогоор нийт 597 хүүхдийг 10 удаагийн арга хэмжээнд хамруулсан байна. Үүнд: Хүнсний тусламж үзүүлэх, даатгалд хамруулах, хувцас, бичиг хэргийн материалын дэмжлэг үзүүлэх, зусланд хамруулах зэрэг зардлуудад зарцуулсан байна.

2.2.5 Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүүхдийн хувь хүний нууц бүрэн хамгаалагдсан байна.

Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэхэд хүүхдийн овог нэр, эмзэг мэдээллийг тушаал шийдвэр, санхүүгийн баримтад кодолж, нууцлан үйлчилгээ үзүүлсэн байна. Тайлант хугацаанд хохирогч хүүхдийн мэдээлэл олон нийтийн сүлжээ болон хэвлэл нийтлэлээр зөвшөөрөлгүй түгээсэн тохиолдол гараагүй хувь хүний нууцыг бүрэн хамгаалсан байна.

2.2.6 Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв 2022-2023 онд урьдчилан сэргийлэх ажил болон хариу үйлчилгээнд оновчтой хуваарилагдаагүйгээс зардал хооронд гүйлгэн зарцуулсан байна.

2022, 2023 онд урьдчилан сэргийлэх ажил болон хариу үйлчилгээний төсвийг оновчтой хуваарилаагүйгээс 22.4 сая төгрөгийн зардлыг гүйлгэн зарцуулсан байна. Үүнд:

Хүснэгт № 8 Батлагдсан төсөв, зарцуулалт / сая.төгрөгөөр /

Зориулалт, арга хэмжээ	Батлагдсан төсөв	Зарцуулалт	Зөрүү
Урьдчилан сэргийлэх	34.8	57.2	-22.4
Хамгаалах, нөхөн сэргээх	90.7	42.3	48.4

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын 2019-2023 оны санхүүгийн баримтууд

1. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 34.8 сая батлагдсанаас гүйцэтгэл 164.3% буюу 57.2 сая,
2. Хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 90.7 сая батлагдсанаас гүйцэтгэл 46.5% буюу 42.3 сая

БҮЛЭГ 3

Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилтийг үнэлэх аргачлал байхгүй, үр дүн, үр нөлөөг дүгнээгүй байна.

3.1 Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлт, аргачлал байхгүй байна.

3.1.1. Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх журам, аргачлалтай байна.

2019-2023 онд аймгийн ХГБХХГ-ын ХШҮ хариуцсан мэргэжилтэн нь дараах журам, аргачлалыг үндэслэл болгон хяналт шинжилгээ үнэлгээг хийсэн байна. Үүнд:

- Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- ХНХС-ын 2017 оны А/121 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж, дүгнэх журам”
- ХНХС-ын 2017 оны А/116 дугаар тушаалаар батлагдсан “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам”-ын 10 дугаар зүйлийн 10.6-д заасан “Түр хамгаалах байрыг ажиллуулж буй төрийн болон төрийн бус байгууллагын удирдлага ажилтнуудаа давтан сургаж, мэргэшүүлж буй байдал, түр хамгаалах байрлуулах үйлчилгээнд Гэр бүл, хүүхэд,

залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, хяналт тавина” заалт

- ГБХЗХГ-ын даргын 2018 оны А/236 дугаар тушаалаар батлагдсан “Хамтарсан багийн үйлчилгээ, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”
- ГБХЗХГ-ын даргын 2020 оны 240 дүгээр тушаалаар батлагдсан “Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн элч, Хүүхдийн эрхийн ажилтны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх аргачлал”

Аймгийн ХГБХХГ-ын ХШҮ хариуцсан мэргэжилтэн хамтарсан баг, түр хамгаалах байр, хүүхдийн төлөө зөвлөл, хүүхдийн тусламжийн 108 утасны үйл ажиллагаанд дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээг 5 удаа хийж холбогдох албан тушаалтнуудад танилцуулсан байна.

3.1.2 Хүүхдийн эрх, хууль журмын хэрэгжилтийн талаар хяналт шалгалт тогтмол явуулсан боловч хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдлын судалгаа, шинжилгээ хийгдээгүй байна.

Аймгийн ХГБХХГ нь мэргэжлийн байгууллагуудтай хамтран 2019-2023 онд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус 3-7 удаагийн хяналт шалгалт, зөвлөн туслах үйл ажиллагааг явуулсан байна. Тухайлбал,

- 2021, 2022 онд МХГ, ЦХ-тэй хамтран “Тоглоомын талбай, хэсэгчилсэн арга хэмжээ” хяналтыг зохион байгуулж, Сүмбэр сумын Засаг дарга, “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-т албан шаардлага, зөвлөмж
- ОБГ-тай хамтран “Болзошгүй осол гал түймэр, цахилгааны аюулаас хүүхдүүдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх” үйл ажиллагааг зохион байгуулж, давхардсан тоогоор 1160 зөрчил илэрч, Сүмбэр сумын ЗДТГ, “Бадрах 70” СӨХ-д зөвлөмжүүд өгсөн
- 2022 онд аймгийн ЦХ, ХГБХХГ-тай хамтран “Хүүхэд-хөдөлмөр”, 2023 онд “Дэврийн гарц”, “Цахим тоглоом” хэсэгчилсэн арга хэмжээ
- 2023 онд СӨБ-ын байгууллага, ЕБС-иудад хяналт, үнэлгээг аймгийн ЗДТГ-ын НБХ, БШУГ, ЭМГ, ГБХЗХГ, сумдын ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан
- 2021, 2022, 2023 онд Боловсролын байгууллагуудын хүүхэд хамгааллын бодлого, хүүхэд хамгааллын баг, сумдын хамтарсан багийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, Политехник коллеж, Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэгт албан шаардлага, боловсролын байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн
- Хүүхэд харах үйлчилгээний стандартын хэрэгжилт
- Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн асуудлаар 5 иргэний материалыг шалгасан

Хүснэгт № 9 Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн зөрчил шийдвэрлэлт

Огноо	Ирсэн гомдол, мэдээллийн тоо	Шалгаж буй хэргийн тоо	Шалгасан зөрчлийн тоо	Хэрэгсэхгүй болсон	Харьяаллын дагуу шилжүүлсэн зөрчлийн тоо	Торгуулийн хэмжээ / сая төгрөгөөр /
2019	-	-	-	-	-	-
2020	6		3		3	-
2021	4	3			1	-
2022	2		2			0.6
2023	3		1	2		0.3
Нийт	15	3	6	2	4	0.9

Эх сурвалж: 2019-2023 оны ХГБХХГ-ын статистик тоон үзүүлэлт

Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль журмын хэрэгжилтийн талаар судалгаа, шинжилгээ хийгдэж байсан эсэхийг тодруулахад:

- 2021 онд ковид 19 цар тахлын үед “Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдлыг тодорхойлж, урьдчилан сэргийлэх” ажлыг 2 удаа зохион байгуулсан байна. Хүүхдийн эрхийн нөхцөл байдлыг тодорхойлох цахим судалгаанд нийт 529 хүүхэд хамрагдсан байна. Тус судалгааны зорилго нь хүүхдийн эрх, хамгааллын асуудал зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилготой байсан боловч цахимаар авсан санал асуулгыг нэгтгээгүй, гарсан үр дүнг тооцож, цаашид ямар ажил хийх талаар төлөвлөөгүй байна.

- 2021 онд аймгийн хэмжээнд сүм хийдийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад шавилан суудаг хүүхдийн нөхцөл байдлын судалгааг МХГ, ЦХ хамтран хийсэн байна. Судалгаагаар сүм, хийдийн чиглэлээр 5 байгууллагад 34 хүүхэд өдрөөр суралцаж, үйл ажиллагаанд хамрагдаж байсан ба тухайн судалгаанд хамрагдсан сүм, хийдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагад хүүхэд хамгааллын бодлогыг танилцуулж, хариуцлагын гэрээ байгуулсан байна. 2021 оноос хойш дахин судалгаа хийгээгүй байна.

2019-2020, 2022-2023 онуудад хийгдсэн хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдлын судалгаа, шинжилгээний талаар баримт материалыг аудитын явцад ирүүлээгүй. Энэ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1¹⁸, 18.2.3¹⁹, 21 дүгээр зүйлийн 21.1²⁰, 21.6²¹-д заасныг тус тус зөрчсөн байна.

Аймгийн ХГБХХГ: Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, холбогдох байгууллагын албан хаагчийн төлөвлөгөөнд хүүхэд хамгааллын талаар судалгаа, шинжилгээ хийх арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.1.3 Хүүхэд хамгааллын чиглэлээр МУ-ын хүүхдийн эрхийн конвенцын тайланд өгсөн зөвлөмжийн биелэлтийг тайлагнаагүй байна.

Аймгийн ХГБХХГ нь МУ-ын хүүхдийн эрхийн конвенцын 5 дугаар тайлангаар өгсөн зөвлөмжийн талаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаагүй, биелэлтийг тайлагнаагүй байна.

3.1.4 Хүүхэд хамгааллын чиглэлээр ДЗОУБ-аас төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ХГБХХГ нь хүүхэд хамгааллын чиглэлээр ДЗОУБ-ын санхүүжилтээр 31.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материал хүлээн авч, данс бүртгэлд тусган зарцуулсан байна. Төсөл, хөтөлбөрийн үр дүнгийн талаар тайлан мэдээ байхгүй байна.

3.1.5 Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу жил бүр аймгийн ХГБХХГ-ын бодлогын баримт бичиг гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. Тус хяналт-шинжилгээ үнэлгээний дүнгээр 2021 онд 82.5%, 2022 онд 86.95%, 2023 онд 83.72%-тай тус тус үнэлэгдсэн, 2020 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна.

Аймгийн ХШҮХ-ээс 2021, 2022 онд тус бүр 4 зөвлөмж, 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт, хэрэгжилтэд нарийвчлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлсэн байна. Тухайлбал:

- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд оролцсон болон хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулахад чиглэсэн нөлөөллийн арга хэмжээний үр дүн, үр нөлөөг салбар хоорондын уялдааг хангах замаар нэмэгдүүлэх
- Түр хамгаалах байрны орчин нөхцөл, үйлчилгээг сайжруулах чиглэлээр төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах
- Өсвөр үеийн дээрэлхэл, түүнээс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг сайжруулах

¹⁸ нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаархи мэдээлэл, судалгаанд нэгдсэн дүгнэлт хийж, цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлох

¹⁹ Хүүхдийн эрхийн тухай хууль болон энэ хуулийн хэрэгжилтэд гурван жил тутамд нэгээс доошгүй удаа анхан шатны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх

²⁰ Монгол Улсын хэмжээнд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, орон нутагт хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавина.

²¹ Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллага хүүхдийн эрхийн хэрэгжилт, хүүхэд хамгааллын нөхцөл байдал, тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын талаар жилд нэгээс доошгүй удаа олон нийтэд тайлагнана

- Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тушаал шийдвэр, төлөвлөгөөний хэрэгжилтийг оны эхнээс жигд ханган хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, хэрэгжилт удаашралтай, хангалтгүй арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч, тухайн жилийн хэрэгжилтийг бүрэн хангах

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1²²-д зааснаар хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл: Хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих тухай зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл 2019-2023 онд нийт 5 удаа хуралдсан байна. Хуралдаанаар тухайн онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталсан боловч төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнээгүй. Хүүхдийн төлөө зөвлөлийн салбар байгууллагуудаас төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан хүлээн авсан боловч нэгтгэсэн тайлан байхгүй байна.

Хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын алба буюу аймгийн ХГБХХГ нь аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн төлөвлөгөө, тайланг тусад нь цэгцэлж, архивын нэгж болгон үдэж архивлаагүй байна.

3.1.6 Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийг үнэлж, дүгнэх шалгуур үзүүлэлт, аргачлалгүй байна.

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор “Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг, байгууллагад эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллах зөвлөмж”-ийг тус тус баталсан байна. Тус тогтоолоор бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалыг батлаагүй байна.

3.1.7 Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн, эерэг нөлөөг тооцож үнэлээгүй байна.

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор “Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг, байгууллагад эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллах зөвлөмж”-ийн хүрээнд 2024 оны байдлаар 53 эцэг эхийн зөвлөл байгуулагдаж, 15 байгууллага хүүхдийн өрөөг тохижуулсан байна. Уг арга хэмжээ нь зөвхөн тоо, мэдээ нэгтгэх байдлаар хэрэгжиж байна.

3.2. Хүүхэд хамгааллын талаар салбар бүрт хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний үр дүн, үр нөлөөг тооцоогүй байна.

3.2.1 Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт гэр бүлийн орчин дахь нөлөөллийг тодорхойлох боломжгүй байна.

2019-2023 онд Хүүхэд хамгааллын тухай хуулийг сурталчлах, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, гэр бүл рүү чиглэсэн сургалт, нөлөөллийн 43 арга хэмжээг эцэг эхчүүд, хүүхдүүдийг хамруулан зохион байгуулсан байна. Гэвч аймгийн хэмжээнд хүүхдийг үл хайхрах хүчирхийллийн тоо жил ирэх тусам нэмэгдсэн, нийт хүчирхийллийн дуудлагын 70 орчим хувь нь гэр бүлийн орчинд үйлдэгдсэн мэдээ гарсан байна.

Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг гэр бүлийн орчинд хэрхэн нөлөөлж байгааг дүгнэх аргачлал байхгүйгээс гэр бүлийн орчны нөлөөллийг тодорхойлоогүй байна.

3.2.2 Боловсролын салбарын байгууллагууд хүүхэд хамгааллын бодлогыг баримтлан ажиллаж байгаа боловч бодлогын хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж тайлагнаагүй байна.

ЕБС, СӨБ, Политехник коллеж зэрэг байгууллагууд хүүхэд хамгааллын бодлого, хөтөлбөр төлөвлөгөө боловсруулж, тайлагнасан байна.

²² Монгол Улсын хэмжээнд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, орон нутагт хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавина.

БШУГ нь 2020 онд Хүүхэд хамгааллын бодлого баталсан боловч хүүхэд хамгааллын чиглэлээр салбар байгууллагуудаас мэдээ, судалгаа тоон мэдээг авч нэгтгээгүй, мэдээллийн сан үүсгээгүй, хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна. Энэ нь хүүхдийн хөгжил, хамгаалал, тэгш хамран сургалт хариуцсан ахлах арга зүйчийн орон тоотой боловч 2019-2023 онд тус орон тоо нөхөгдөөгүй, өөр мэргэжилтэнд давхар хариуцуулснаас шалтгаалсан байна.

Аудитаар аймгийн лаборатори 5 дугаар сургууль, Политехник коллежийн дотуур байрны “ЕБС-ийн, дотуур байрын орчин, үйлчилгээ” шалгах хуудсаар үнэлсэн үзүүлэлтээр шаардлага хангасан байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр тулгамдсан төрийн бодлогын шийдэл хэрэгтэй ямар нэгэн асуудал байна уу гэж тодруулахад

- Политехник коллеж мэргэжлийн сэтгэл зүйчийн орон тоо тоотой болох, зориулалтын шаардлага хангасан дотуур байртай болох гэсэн санал өгсөн.

Иймд хүүхдийн хөгжил, хамгаалал, тэгш хамран сургалт хариуцсан ахлах арга зүйчийн сул орон тоог нэн дариу нөхөх, Боловсролын салбарын хүүхэд хамгааллын мэдээллийн сан үүсгэх, бодлогын хэрэгжилтийг үнэлэх, дүн шинжилгээ хийх, дээрх зөрчилтэй асуудлыг салбарын хэмжээнд шийдвэрлэх шаардлагатай байна.

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлд салбар байгууллагуудын үйл ажиллагаа сайжруулах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.2.3 Эрүүл мэндийн салбарт хүүхэд хамгааллын нэгдсэн тоон мэдээлэл байхгүй байна.

Аймгийн ЭМГ нь эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн талаар бүртгэл хөтлөөгүй, тоон мэдээлэл тодорхойгүй, хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, тайлан байхгүй байна.

Хамтарсан багийн үйл ажиллагаанд өрхийн эмнэлэг тогтмол оролцож шаардлагатай тусламж үйлчилгээг тухай бүр үзүүлж ирсэн бөгөөд ЭМГ-ын оролцоо хангалтгүй байна.

ЭМГ-аас 2019-2023 онд хүүхэдтэй холбоотой гэж ирүүлсэн тоон мэдээлэл дараах байдалтай байна.

Хүснэгт №10 Эрүүл мэндийн салбарын 2019-2023 оны тоон мэдээлэл

Огноо	19 нас хүртэлх төрөлтийн тоо	19 нас хүртэлх бэлгийн замын халдварт өвчний тоо	19 нас хүртэлх үр хөндөлтийн тоо
2019	27	14	4
2020	11	7	3
2021	21	2	5
2022	12	12	1
2023	20	17	0
Нийт	91	52	13

Эх сурвалж: ЭМГ-аас ирүүлсэн судалгаа

Хүснэгтээс харахад: эрсдэлт бүлгийн хүүхдүүдэд урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулдаг боловч дээрх тоон мэдээлэлд үндэслэн хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг аудитын явцад ирүүлээгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцад эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн орон нутгийн ажилтан, албан тушаалтан, эсхүл цагдаагийн байгууллагын алба хаагчид заавал мэдээлнэ” гэж тусгасан байна.

2019-2023 онд Эрүүл мэндийн салбар байгууллагаас Хүүхдийн тусламжийн 108 утсанд 2 удаагийн дуудлагыг өгсөн нь хуулиар хүлээсэн чиг үүрэг хангалтгүй, оролцоо сул байна. Иймд ЭМГ-аас аймгийн хэмжээний эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээллийн сан үүсгэх, нэгтгэн дүн шинжилгээ хийх шаардлагатай байна.

Хүүхдийн төлөө зөвлөлд салбар байгууллагуудын үйл ажиллагаа сайжруулах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.2.4 Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгаалал хангагдсан байна.

Аймгийн хэмжээнд Эрх нь зөрчигдсөн, хүчирхийлэлд өртсөн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ авсан хүүхдүүдийн хувийн мэдээллийг задлах, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийг зөрчсөн тохиолдол гараагүй, ХГБХХГ болон Нийгмийн бодлогын хэлтэст мэдээлэл ирээгүй байна.

3.2.5 Олон нийтийн арга хэмжээ, Соёл, спортын үйл ажиллагаатай холбоотой хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд бүртгэлийн системийн хөгжүүлэлтийг сайжруулах шаардлагатай байна.

Аймгийн ХГБХХГ нь *“Соёл спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах”* журмын хэрэгжилтийг хангаж сургууль, цэцэрлэг болон бусад сургалтын байгууллагуудад мэдээлэл өгч, сургалт зохион байгуулсан байна. “Үндэсний баяр наадмын тухай хууль”, “Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Соёл спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах журам”-ын дагуу хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг баяр наадмын арга хэмжээнд аюулгүй байдлыг ханган ажилласан байна.

ХГБХХГ-ын тоон мэдээллээр 2019-2023 онд нийт 25 хурдан морины уралдаан зохион байгуулсан ба уралдаанд нийт 532 уралдаанч хүүхэд оролцсоноос мориноос унаж бэртсэн хүүхдийн тоо 13 байгаа ба 2021 оны мэдээлэл ирээгүй байна.

Аудитаар аймгийн ХГБХХГ-ын Able системд бүртгэсэн мэдээллийг тулгахад 2021 оны мэдээллийг оруулаагүй байна. Able системээр тайлант хугацаанд нийт 13 хурдан морины уралдаанд давхардсан тоогоор 673 хүүхдийн бүртгэл хийгдсэн боловч мориноос унаж бэртсэн хүүхдийн тоон мэдээлэл бүртгэгдээгүй байна. Бүртгээгүй шалтгааныг тодруулахад хурдан морины уралдааны гарааны байршилд сүлжээ байдаггүйгээс Able системийг ашиглах боломжгүй гэсэн шалтгаанаар бүртгэлгүй орхигдуулсан байна.

3.2.6 Аймгийн хэмжээнд гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгааллын бодлого байхгүй боловч тухай бүр шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Аймгийн ХГБХХГ нь 2021 онд байгууллагын “Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө”-г баталсан боловч аймгийн хэмжээний гамшгийн үеийн хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийг тусад нь боловсруулаагүй байна.

Аймгийн ОБГ нь 2019-2023 онд Говьсүмбэр аймгийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр аймгийн ИТХ-аар батлуулж хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Уг төлөвлөгөөний дагуу сургууль цэцэрлэг, болон дотуур байрын гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх, газар хөдлөлтийн тэсвэрийг үнэлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор өсвөр үе болон бага насны хүүхдүүдэд гамшгийн үеийн чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр дадлага, сургуулилт хийж, радоны хуримтлалын хэмжээг тогтоох тандалт судалгаа зэргийг хийж ажилласан байна.

Гамшиг, гамшгийн онцгой байдлын үеийн ажиллагаанд оролцдог алба хаагчдад эрүүл мэнд болон сэтгэл зүйн анхан шатны мэдлэгийг эзэмшүүлсэн байна.

Хүснэгт № 11 Гамшиг, осол аюулт үзэгдэлд өртсөн хүүхдийн тоо, мэдээлэл /2019-2023/

Огноо	Гал түймрийн аюулд өртсөн хүүхдийн тоо	Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осолд өртсөн хүүхдийн тоо
2019	-	-
2020	2	-
2021	2	-
2022	-	-
2023	-	-
Нийт	4	-

Эх сурвалж: ОБГ-аас ирүүлсэн судалгаа

Хүснэгтээс харахад 2019, 2022-2023 онд гамшиг, осол аюулт үзэгдэлд өртсөн хүүхэд байхгүй, 2020-2021 онд 4 хүүхэд гамшигт өртсөн байна.


3.3 Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа эерэг үр дүнг үзүүлээгүй байна.

3.3.1 Аймгийн ХГБХХГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Хүүхдийн эрхийн олон улсын конвенцын талаар арга хэмжээ тусгагдаагүй байна.

Аймгийн ХГБХХГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Хүүхдийн эрхийн олон улсын конвенцод нэгдсэн үүргийн талаар арга хэмжээ тусгагдаагүй, тайлан мэдээ гаргаагүй байна.

3.3.2 Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага, мэдээллийн мөрөөр шаардлагатай арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлээгүй байна.

2019-2023 онд хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд нийт 215 дуудлага мэдээлэл ирсэн байна. Үүнд:




Дүрслэл № 4 Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд ирсэн дуудлагын тоо

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн дуудлага 2019 онтой харьцуулахад жил бүр 4-21-ээр өссөн, 2019 онд 32, 2023 онд 59.5%-аар өсөж 51 дуудлага мэдээлэл бүртгэгдсэн байна.

Нийт дуудлагын 70-96%-ийг хүүхэд хамгаалалтай холбоотой, үлдсэн 4-30%-ийг зөвлөгөө хүссэн дуудлага эзэлж байна.

Эх сурвалж: Хүүхдийн тусламжийн 108 утасны мэдээллийн сан

Дүрслэл № 5 Хүүхэд хамгаалалтай холбоотой дуудлагыг хүчирхийллийн хэлбэрээр нь ангилж харуулбал:



Эх сурвалж: Хүүхдийн тусламжийн 108 утасны мэдээллийн сан

Дүрслэлээс харахад: Нийт дуудлагын 36%-ийг бие махбодын хүчирхийлэл, 31%-ийг үл хайхрах хүчирхийлэл, 17%-ийг сэтгэл санааны хүчирхийлэл, 11%-ийг бэлгийн, үе тэнгийн хүчирхийлэл болон гэрээс дайжсан, үлдсэн 5%-ийг бусад хүчирхийлэл эзэлж байна.

Манай аймгийн хувьд сүүлийн жилүүдэд үл хайхрах хүчирхийлэл нэмэгдсээр байна. Бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны хүчирхийлэл огт буураагүй үзүүлэлттэй байна.

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд ирсэн нийт дуудлагыг мэдээллийн эх үүсвэрээр задалж харуулбал:

- ❖ 2019, 2020 онд мэдээллийн эх үүсвэрээр ангилаагүй
- ❖ 2021 онд гэр бүлийн орчноос 21, олон нийтийн арга хэмжээ 20, боловсролын салбараас 1, тодорхойгүй 1
- ❖ 2022 онд гэр бүлийн орчноос 42, боловсролын салбараас 5, олон нийтийн арга хэмжээ 3, тодорхойгүй 3
- ❖ 2023 онд гэр бүлийн орчноос 43, боловсролын салбараас 6, эрүүл мэндийн салбараас 2

Нийт дуудлагын 72%-ийг гэр бүлийн орчноос, 16%-ийг олон нийтийн арга хэмжээнээс, 8%-ийг боловсролын салбараас, 1.4%-ийг эрүүл мэндийн салбараас, 2.6%-ийг бусад эх үүсвэрээс мэдээлсэн байна.

Нийт дуудлагын 51%-ийн ХГБХХГ, 32%-ийг Сүмбэр сум, 12%-ийг Шивээговь сум, 5%-ийг Баянтал сумын хамтарсан баг хүлээн авч шийдвэрлэсэн байна. 2019-2022 онд хүлээн авсан дуудлага бүгд хаагдсан ба 2023 онд 1 дуудлага хаагаагүй хяналтын шатанд байна.

2019-2023 онд шийдвэрлэсэн нийт дуудлагаас түүврийн аргаар 45 дуудлагад дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

- 2019-2020 онд шийдвэрлэсэн 9 дуудлагын нөхцөл байдлын үнэлгээ, хариу үйлчилгээ, явцын тэмдэглэлийг баталгаажуулаагүй, хэзээ хаасан, хаана шийдвэрлэсэн тодорхойгүй
- Нөхцөл байдлын үнэлгээг журамд заасан хугацаанд хийгээгүй 10, огт хийгдээгүй 6 нийт 16 дуудлага байна /2021 онд 6, 2022 онд 4, 2023 онд 6 /

Эдгээр зөрчил нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4²³, 12 дугаар зүйлийн 12.1²⁴, 12.3²⁵, ХНХС, ХЗДХС-ын 2017 оны А/120,А/178 дугаар тушаалаар батлагдсан “Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3²⁶, 2.19²⁷ дахь заалтуудыг зөрчсөн байна.

Энэ нь аймгийн ХГБХХГ-ын ЭБАТ 3 удаа солигдсон, ЭБАТ-ууд ажил хүлээлцэх хооронд хугацаа алдсан, хууль журамд заасан эрх үүргээ цаг хугацаанд нь биелүүлээгүй, удирдлага хяналт хэрэгжүүлээгүй зэргээс шалтгаалсан нь эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд учирсан, учирч болзошгүй сөрөг үр дагаврыг хугацаа алдаж тодорхойлох, цаашлаад хариу үйлчилгээг төлөвлөх хугацаа сунжрах зэрэг эрсдэл үүссэн байна.

Иймд аймгийн ХГБХХГ-т Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага, мэдээллийг холбогдох байгууллага, ЭБАТ-д нэн даруу шилжүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ, дүн шинжилгээг хийж, үр дүнгийн мөрөөр шаардлагатай арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аймгийн Прокурорын газар 2023 оны 2 дугаар улирлын гүйцэтгэлийн ажлын төлөвлөгөөний дагуу хүүхдийн тусламжийн 108 утсанд 2022.12.21-2023.06.01-ний өдрийг хүртэл тус аймагтай холбоотой 18 гомдол, мэдээлэл ирүүлснийг шийдвэрлэлтийн байдлыг нэг бүрчлэн хянасан байна. Тус шалгалтаар дараах зөрчил илэрч, илэрсэн зөрчлийг арилгуулах, давтан гаргуулахгүй байх, холбогдох хууль, журмын хэрэгжилтийг хангуулах тухай Прокурорын шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

1. Нийт 6 гомдол, мэдээллүүдийг цахим хэлбэрээр бүртгэлд авсан боловч гомдол, мэдээллийг ирүүлсэн хүний овог нэр, өөрийн нэр, оршин суугаа газар, шуудангийн хаяг тодорхой бус, хэнд ямар тусламж, дэмжлэг шаардлагатай байгаа, хэн хүчирхийлэлд өртөөд байгаа нь ойлгомжгүй
2. ЭБАТ, ХЭУБ нь нийт 9 гомдол мэдээллийг хүлээн аваад зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байхад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулалгүй бусад байгууллага албан тушаалтанд шилжүүлж хуульд заасан үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй
3. ЭБАТ нь байгууллагын бүртгэлд бүртгэсэн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг харьяалах Прокурорын газрын нэгдсэн бүртгэлд даруй бүртгүүлэх тухай хуулийн заалтыг биелүүлээгүй
4. Эрх бүхий байгууллага нь зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн бүртгэлийг сар тутам Прокурорт танилцуулах ёстой атал хэрэгжүүлж ажиллаагүй гэсэн байна.

Аймгийн ХГБХХГ нь 2023.06.28-ны өдрийн 159 дүгээр албан бичгээр Прокурорын газрын албан шаардлагын дагуу ЭБАТ-д сахилгын шийтгэл ногдуулж хариуг хүргүүлсэн байна.

3.3.3 Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээ нь түргэн шуурхай хүргээгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай, Эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн дагуу хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлж байна.

Аймгийн хэмжээнд ХГБХХГ, Сүмбэр, Шивээговь, Баянтал сумдын хамтарсан багийн шийдвэрлэсэн 2019-2023 оны нийт 215 дуудлага мэдээллээс түүврийн аргаар 45 дуудлагад дүн шинжилгээ хийхэд хүүхэд хамгааллын хариу арга хэмжээг дараах байдлаар үзүүлж байна. Үүнд:

1. Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах - 45 дуудлага хүлээн авсан.

²³ Энэ зүйлд заасны дагуу ирүүлсэн мэдээ, мэдээллийг хүлээн авсан ажилтан, албан тушаалтан тухайн нөхцөл байдлыг газар дээр нь үнэлж, холбогдох тэмдэглэлийг нийгмийн ажилтан, хамтарсан багт хүргүүлнэ.

²⁴ Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх зорилгоор нөхцөл байдлын үнэлгээ хийнэ.

²⁵ Аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хорооны нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан өөрийн санаачилгаар, эсхүл хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлэх явцад холбогдох этгээдээс ирүүлсэн мэдээ, мэдээллийг үндэслэн нөхцөл байдлын үнэлгээ хийнэ.

²⁶ Нөхцөл байдлын үнэлгээг мэдээлэл авснаас хойш яаралтай үед нэн даруу, бусад нөхцөлд 72 цагийн дотор хийнэ.

²⁷ Хамтарсан багийн нарийн бичгийн дарга нөхцөл байдлын үнэлгээний талаарх мэдээллийг холбогдох мэдээллийн санд оруулна.

2. Нөхцөл байдлын үнэлгээ хийх - 25 дуудлагын нөхцөл байдлын үнэлгээг цаг хугацаа алдаж хийсэн
3. Аюулгүй байдлыг хангах - Түр хамгаалах байраар 4 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн
4. Дэмжих, холбон зуучлах-Архины эмчилгээ 3,эцэг эхэд зөвлөгөө өгсөн 10,сэтгэл зүйн үйлчилгээ 5,эрүүл мэндийн үйлчилгээ 5, боловсролын үйлчилгээ 1, нийгмийн халамж 1
5. ХЭХЗХ-ны үйлчилгээ үзүүлэх - Өмгөөллийн үйлчилгээ 2, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн 1, хуулийн арга хэмжээ 7
6. Гэр бүлд нь эргэн нэгтгэх- Түр хамгаалах байраар үйлчлүүлсэн 4 хүүхдийг буцааж гэр бүлд нь эргэн нэгтгэсэн.

Аймгийн ХГБХХГ-аас сэтгэл зүй, хууль зүй, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж болон бусад шаардагдах үйлчилгээнд холбон зуучилж байгаа боловч аймгийн хэмжээнд сэтгэцийн эрүүл мэндийн асуудал орхигдсон, хүүхдийн сэтгэцийн эмчийн орон тоогүй байна.

Хүүхэд хамгааллын хариу арга хэмжээнд хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх, асрамж халамжид хүлээлгэн өгсний дараа хяналт, дэмжлэг үзүүлнэ гэсэн боловч энэ үйлчилгээг хэрхэн үзүүлсэн талаар баримт материал байхгүй байна. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнх, хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн хэрэгцээнд нийцсэн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ байхгүй байна.

Жишээ 2: Аймгийн ХГБХХГ, хамтарсан багийн гишүүдийн дунд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах / дохионы хэл г.м/ сургалтад хамрагдсан албан хаагч байхгүй байна.

Хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн систем байхгүйгээс хүүхэд шилжин суурьшихад тухайн хүүхэд өмнө нь ямар үйлчилгээ авсныг мэдэх боломжгүй байна.

2019-2023 онд түр хамгаалах байраар нийт 95 хүүхдэд 1106 өдөр үйлчилгээ үзүүлсэн бөгөөд аймгийн хэмжээнд 1 түр хамгаалах байртай, түр хамгаалах байрыг “Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS 6040:2019 стандарт” дагуу тулган баталгаажуулахад ихэнх шаардлагыг хангасан байна. Тухайлбал:

- Орон сууцны зориулалттай 5 давхар барилгын 1 давхарт байрладаг, 3 өрөөтэй, гэрээгээр багш мэргэжилтэй тэтгэвэрт гарсан 2 багш ажилладаг
- Гадна, дотор хяналтын камертай, камер нь 14 хоног бичлэг хадгалдаг, унтлагын болон ариун цэврийн өрөөнд камер байрлуулаагүй
- Хүүхдийг байрлаж байх хугацаанд тухайн байршилд хамаарах ЕБС, СӨБ-тэй хамтран боловсролын үйлчилгээ үзүүлдэг
- Бүх ажилтныг жилд 1 удаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан
- Хохирогчийг хүлээн авч ярилцах, ганцаарчилсан зөвлөгөө өгөхөд зориулагдсан өрөө байхгүй
- Галын аюулгүй байдлыг хангасан, гамшиг, онцгой байдлын үед ашиглах орц гарцгүй
- Мэргэжлийн сэтгэл зүйч, хүүхэд хамгааллын ажилтангүй
- Түр хамгаалах байранд үйлчилгээ үзүүлэх ажилтны сургалтад хамрагдаж, гэрчилгээ аваагүй боловч бусад аймаг, дүүргийн түр хамгаалах байртай танилцах, туршлага судлах хэлбэрээр сургалтад хамрагдсан




3 сумын хамтарсан багийн 28 гишүүдтэй уулзалт зохион байгуулж, хамтарсан багийн үйл ажиллагааг ХНХС, ХДХС, ЭМС-ын 2017 оны А/173, А/251, А/3801 дугаар тушаалаар батлагдсан “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ын хүрээнд шалгах хуудсаар үнэлж, ярилцлага хийж, тайлбар тодруулга авсан.

Хамтарсан багийн гишүүнээр ажилласан хугацааг тодруулахад 1 дэх жилдээ 9, 1-3 дахь жилдээ 16, 4-ээс дээш жилдээ 3 гишүүн ажиллаж байна.



Хамтарсан багийн нийт гишүүдийн 64% нь Хүүхэд хамгааллын чиглэлээрх сургалтад хамрагдсан байна.

Дүрслэл №6 Сумдын хамтарсан багуудын туршлага, сайн жишээ



Хамтарсан багуудад илэрсэн нийтлэг зөрчлүүдийг дурдвал:

- Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг сүүлийн 5 жилд дүгнээгүй
- Хувийн хэрэг, материалуудыг үдэж архивлаагүй, архивд хүлээлгэн өгөөгүй, байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад батлаагүй, хэн авах нь тодорхойгүй, нийгмийн бодлогын мэргэжилтний өрөөнд хадгалагдаж байгаа бөгөөд баримтыг хадгалах аюулгүй байдал, хадгалалтын шаардлага хангаагүй
- Хамтарсан багийн хурлын тэмдэглэлүүд бүрэн хөтлөгдөөгүй / Баянтал сум /
- Хувийн хэргийг кодлоогүй, нууцлал журмын шаардлага хангаагүй / Баянтал сум /

Эдгээр зөрчил нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.²⁸, ХНХС, ХЗДХС, ЭМС-ын 2017 оны А/173, А/251, А/3801 дугаар тушаалаар батлагдсан “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.2²⁹, 4.2.7³⁰, 4.2.10³¹ дахь заалтуудыг зөрчсөн байна.

Энэ нь хамтарсан багийн гишүүд тогтвор суурьшилгүй ажилладаг, баримт материал бүрэн хүлээлцдэггүй, хүүхэд хамгааллын чиглэлээр сургалтад тогтмол хамрагдаагүй зэрэг нөхцөл байдлаас шалтгаалж байна.

²⁸ архивын баримтын хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавих

²⁹ Урьдчилан сэргийлэх ажил, үйлчилгээний хугацаатай хөтөлбөр, төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг хангах

³⁰ Үйлчлүүлэгчийн хувийн хэрэгт аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээ, үйлчилгээний явц, ярилцлагын тэмдэглэл, үйл явцын тэмдэглэл, нотлох бусад баримтыг хавсарган үйлчилгээг баримтжуулж, нууцлалыг хадгална.

³¹ Нарийн бичиг үйлчилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтээр зогсоох, үйлчилгээний үр дүнг үнэлэх, хувийн хэргийг хаах үед холбогдох баримтыг хавсарган, хянаж, гарын үсэг зурж, баталгаажуулна.

Иймд хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх сургалтад тогтмол хамруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах анхан шатны болон гүнзгийрүүлсэн шатны сургалт зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

Аудитын явцад хийгдсэн хамтарсан багуудын уулзалтаар хүүхэд хамгааллын чиглэлээр тулгамдсан төрийн бодлого шийдвэрт өөрчлөлт оруулах дараах саналуудыг ирүүлсэн. Үүнд:

1. Хамтарсан багийн гишүүд ажил үүргээ гүйцэтгэж явахад амь нас, аюулгүй байдлыг хамгаалах талаар хууль журамд тусгагдаагүй
2. Хүүхдийн тусламжийн 108 утсанд зорилтот бус дуудлага өгсөн иргэнд хариуцлага тооцох механизм байхгүй
3. Давтан зөрчил үүсгэж байгаа эцэг эхэд хариуцлага тооцох асуудал сул, хариуцлагыг чангатгах шаардлагатай
4. Нийгмийн ажилтнууд дарамт шахалт, үүрэг хариуцлага өндөр улмаас тогтвор суурьшилгүй ажилладаг. Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах шаардлагатай
5. Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалт байнга хийгддэг боловч үр дүнгүй байдаг. Гүнзгийрүүлсэн шатны, онол практик хосолсон сургалтад хамруулах хэрэгтэй байна. /Жишээ нь Дохионы хэлний сургалт/
6. Хүүхэд хамгааллын тогтолцоонд оролцогч үүрэг хүлээгч байгууллагуудын салбар хоорондын уялдаа муу байгааг сайжруулах
7. Сумын нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн хамтарсан багийн нарийн бичгээр ажилладаг учраас ажлын ачаалал их байдаг. Иймд суманд нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн орон тоог бий болгох
8. Улсын төсвөөс хамтарсан багийн гишүүдийн урамшуулал, үйл ажиллагааны зардалд төсөв мөнгө олгогдоогүй
9. “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ын нөхцөл байдлын үнэлгээ хийх маягыг бөглөхөд хугацаа их шаарддаг. Журамд өөрчлөлт оруулж хялбарчлах шаардлагатай гэсэн байна.

3.3.4 Аймгийн Цагдаагийн хэлтэс хүүхдийн эсрэг гэмт хэргийн нөхцөл байдлын судалгааг хийж, урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээнүүд тогтмол зохион байгуулсан байна.

2019-2023 оны аймгийн хэмжээнд гэмт хэрэгт холбогдсон болон гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоон үзүүлэлт дараах байдалтай байна.

Дүрслэл №7 Аймгийн хэмжээнд гэмт хэрэгт холбогдсон болон гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоо



Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоо 2019-2023 онд нийт 70 байна. 2019 онтой харьцуулахад жил бүр 9-53%-аар өсөж, 2023 онд 19 байна.

Гэмт хэрэгт холбогдож ялагдсан хүүхдийн тоо 2019 онтой харьцуулахад 2023 онд 66.6%-аар өсөж 6 байна.

Эх сурвалж: 1212.тп статистик үзүүлэлт, аймгийн ЦХ-ээс ирүүлсэн тоон мэдээ

Аймгийн Цагдаагийн хэлтэс 2021 онд 2017-2020 онд гэмт хэрэгт холбогдсон болон гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн судалгаа, 2022 онд үйлдэгдэж бүртгэгдсэн хүүхдийн эсрэг, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын судалгааг тус тус хийсэн байна.

Аймгийн хэмжээнд 2019-2023 онд хүүхэд өртөж хохирсон 70 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодруулахад 80 орчим хувийг дараах нөхцөл байдал эзэлж байна. Үүнд:

Эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс:

- ✓ Хүүхдэд тавих анхаарал халамж, хараа хяналт сул
- ✓ Бага насны хүүхдийг үл хайхардаг, хуульд заасан үүргээ биелүүлдэггүй
- ✓ Хувь хүний зан төлөв, харилцааны доголдол

- ✓ Анхаарал болгоомжгүй байдал
- ✓ Согтууруулах ундааны хэрэглээ

Бусад хүчин зүйлс:

- Ажилгүйдэл, ядуурал
- Нийгмийн хандлага
- Үе тэнгийнхний дээрэлхэл, цахим орчны хэрэглээ, донтолт

Цаашид хийж хэрэгжүүлэх ажил:

1. “Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлүүдийн дийлэнх нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэр бүл, ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа тул шинээр батлагдсан “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн хэрэгжилтийг хангах, согтууруулах ундааны хэрэглээг багасгах гэсэн байна.

2019-2023 онд Аймгийн Цагдаагийн хэлтэс, Прокурорын газар, ХГБХХГ, ГХУСЗ, БШУГ, ЭМГ, Сүмбэр сумын ЗДТГ зэрэг байгууллагууд хамтран давхардсан тоогоор 55 удаагийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна.

3.3.5 Аймгийн БШУГ, ЭМГ-аас хүүхэд хамгаалалтай холбоотой тоон үзүүлэлт гаргаагүй байна.

Аудитаар БШУГ, ЭМГ, ОБГ, ЦХ, ШТГ-аас хүүхэд хамгаалалтай холбоотой дараах тоон үзүүлэлтийг гаргаж ирүүлсэн байна. Тухайлбал:

1. Аймгийн БШУГ-аас хүүхэд хамгаалалтай холбоотой тоон мэдээлэл ирүүлээгүй
2. Аймгийн ЭМГ-аас 2019-2023 оны 19 хүртэлх насны төрөлт, үр хөндөлт, бэлгийн замын халдварт өвчний тоо
3. Аймгийн ОБГ-аас 2019-2023 оны гамшиг, осол, аюулт үзэгдэлд өртсөн хүүхдийн тоон мэдээллийг ирүүлсэн
4. Аймгийн ЦХ-ээс 2019-2023 оны хүүхдийн эсрэг гэмт хэргийн тоо, гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо
5. Аймгийн ШТГ-аас 2019-2023 оны хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдийн тоо

Хүүхэд хамгааллын тогтолцоонд боловсрол болон эрүүл мэндийн салбарын оролцоо, хамтын ажиллагаа чухал үүрэгтэй боловч аймгийн БШУГ, ЭМГ-аас хүүхэд хамгаалалтай холбоотой тоон үзүүлэлт гаргаж байгаагүй байна.

Аймгийн ХГБХХГ-ын хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага, гэмт хэрэг холбогдсон хүүхдийн тоо, хүүхдийн эсрэг гэмт хэргийн тоо, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдийн тоо, эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн тоо зэрэг статистик мэдээний үзүүлэлтийг холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэлтэй тулгахад дараах зөрүү үүссэн байна. Тухайлбал:

1. Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд ирсэн дуудлагын бүртгэлийн тоог аймгийн ХГБХХГ нь статистик тоон мэдээндээ 1-ийг илүү, 8-ыг дутуу тусгасан

Хүснэгт №12 Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд ирсэн дуудлагыг статистик тоон мэдээтэй харьцуулсан харьцуулалт

Огноо	Статистик мэдээний тоо	Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд ирсэн дуудлагын тоо	Зөрүү
2019	31	32	(1)
2020	32	36	(4)
2021	40	43	(3)
2022	53	53	-
2023	52	51	1
Нийт	208	215	(7)

Эх сурвалж: Аудиторын хийсэн харьцуулалт

2. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо 1-4, Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдийн тоо 1-3, Хүүхдийн эсрэг гэмт хэргийн тоо 4-13-аар тус тус зөрүүтэй

Хүснэгт №13 Аймгийн ЦХ, ШТГ-аас ирүүлсэн тоон үзүүлэлтийг аймгийн ХГБХХГ-ын гаргасан тоон үзүүлэлттэй харьцуулсан байдал:

Огноо	Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо		Зөрүү	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдийн тоо		Зөрүү	Хүүхдийн эсрэг гэмт хэргийн тоо		Зөрүү
	ЦХ	ХГБХХГ		ШТГ	ХГБХХГ		ЦХ	ХГБХХГ	
2019	2	4	(2)	3	2	1	10	10	-
2020	2	2	-	0	3	(3)	11	11	-
2021	1	1	-	2	1	1	12	12	-
2022	8	4	4	3	2	1	18	31	(13)
2023	6	5	1	3	5	(2)	19	15	4
Нийт	19	16	3	11	13	(2)	70	79	(9)

Эх сурвалж: Аудиторын хийсэн харьцуулалт

3. Эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн тоо 4-209-өөр илүү, дутуу

Хүснэгт №14 ХГБХХЕГ-аас ирүүлсэн эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн тоог аймгийн ХГБХХГ-ын гаргасан тоон үзүүлэлттэй харьцуулсан байдал:

Огноо	Эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн тоо		Зөрүү
	ХГБХХЕГ	ХГБХХГ	
2019	326	117	(209)
2020	231	235	4
2021	268	236	(32)
2022	195	254	59
2023	358	352	(6)
Нийт	1378	1194	(184)

Эх сурвалж: Аудиторын хийсэн харьцуулалт

Аймгийн ХГБХХГ нь тоон үзүүлэлтийг зөрүүтэй нэгтгэсэн, дүн шинжилгээ хийгээгүйн улмаас эрсдэл буураагүй байна.

Аудитаар нийт 60.8 сая төгрөгийн зөрчил илэрч, 60.8 сая төгрөгийн 1 албан шаардлага, 11 зөвлөмж, УАГ-т уламжлах 4 санал хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Аймгийн хэмжээнд Хүүхэд хамгааллын талаар хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй байна.
2. Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар нь хүний нөөцийн дутагдалтай, ХГБХХЕГ-аас хяналт тавьж ажиллаагүйгээс хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, зарим чиг үүргийг орхигдуулсан байна.
3. Хүүхэд хамгааллын бодлогын хэмжээнд мэдээллийн удирдлагын нэгдсэн систем байхгүйгээс хүүхэд хамгааллын тоон мэдээ зөрүүтэй, дуудлага, мэдээллийн мөрөөр шаардлагатай арга хэмжээг түргэн шуурхай үзүүлээгүй, салбар хоорондын уялдаа холбоо байхгүй байна.
4. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бодлогыг нэгтгэн тайлагнах үүрэг бүхий аймгийн Эрүүл мэндийн газар болон Боловсролын газрын оролцоо сул байна.
5. Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилт хүрэлцээтэй боловч оновчтой хуваарилаагүй байна.
6. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд оролцогч байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоогүйн улмаас төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэж, үр нөлөөг тооцоогүй байна.
7. Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийг үнэлж, дүгнэх шалгуур үзүүлэлт, аргачлалгүйгээс хүүхдийн төлөө зөвлөл хяналт хэрэгжүүлээгүй байна.
8. Эрх бүхий албан тушаалтан солигдсон, хамтарсан багийн гишүүд тогтвор суурьшилгүй ажиллаж байгаагаас шалтгаалж эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээг түргэн шуурхай үзүүлээгүй байна.
9. Аймгийн Цагдаагийн хэлтэс хүүхдийн эсрэг гэмт хэргийн нөхцөл байдлын судалгааг хийснээр урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулсан байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлд:

1. Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих
2. Хүүхэд хамгааллын чиглэлээр салбар байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, жил бүрийн батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг тооцох

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт:

1. Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүлээсэн чиг үүргийг жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх
2. Статистик тоон үзүүлэлт, мэдээ тайланг үнэн зөв гаргах, үзүүлэлт бүрээр дүн шинжилгээ хийж эрсдэлийг тодорхойлон, асуудлыг эрэмбэлж, дарааллын дагуу шийвэрлэх, мэдээ тайланг албажуулдаг байх
3. Сэтгэл зүйчийн орон тоонд албан тушаалын тодорхойлолтод заасан шалгуурыг хангасан албан хаагч ажиллуулах
4. Хуульд заасан чиг үүргийн хүрээнд түр хамгаалах байрны урсгал зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах
5. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, холбогдох байгууллагын албан хаагчийн төлөвлөгөөнд хүүхэд хамгааллын талаар судалгаа, шинжилгээ хийх арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнах
6. Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага, мэдээллийг холбогдох байгууллага, ЭБАТ-д нэн дариу шилжүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ, дүн шинжилгээг хийж, үр дүнгийн мөрөөр шаардлагатай арга хэмжээ авч ажиллах
7. Хүүхэд хамгааллын мэргэжилтэн, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх, үр өгөөжөө үзүүлэхүйц сургалтад тогтмол хамруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах анхан шатны болон гүнзгийрүүлсэн шатны сургалтад хамруулах
8. Хүүхэд хамгаалалтай холбоотой арга хэмжээний төлөвлөгөө, тайлан, хувийн хэрэг, холбогдох материалыг байгууллага болон чиг үүргийн дагуу ангилан нууцлалын журмыг хангаж, үдэж архивлах, холбогдох хууль, журмын дагуу архивд хүлээлгэн өгөх

Сумдын Засаг дарга нарт:

1. Хамтарсан багийн үйл ажиллагаатай холбоотой бүх баримт бичиг, хувийн хэрэг, холбогдох материалуудыг нууцлалын журмыг ханган үдэж архивлах, архивд хүлээлгэн өгөх

УЛАМЖЛАХ САНАЛ

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад уламжлуулах саналтай байна. Үүнд:

1. Хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн сан бий болгох, одоо ашиглагдаж буй мэдээллийн сангийн ашиглалтыг сайжруулах, тоон үзүүлэлтийн давхардлыг арилгаж бодит тоон үзүүлэлтэд нийцүүлэн статистик үзүүлэлт тооцох аргачлалыг шинэчилж, статистик мэдээний цахим системтэй болох
2. Салбарын хэмжээнд хүний нөөцийн болон нийгмийн хамгааллын бодлогыг уялдуулан боловсруулж, орон нутгийн байгууллагуудын бүтэц оновчтой боловсруулах, төрийн захиргааны албан тушаалын сул орон тоо нөхөгдөхгүй байгаа асуудалд дүн шинжилгээ хийж, зарим орон тоог төрийн үйлчилгээ болгож шийдвэрлэх боломжтой эсэхийг судлах
3. Салбар байгууллагуудын хэмжээнд хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийг үнэлж, дүгнэх шалгуур үзүүлэлт, аргачлалыг боловсруулж, батлах
4. Эрсдэлт нөхцөлтэй холбоотой хувийн хэргийг хэрхэн ангилах, архивын нэгж болгох асуудлыг нэгдсэн байдлаар шийдвэрлэж орон нутгийн байгууллагуудад чиглэл өгөх, нэгдсэн нэг ойлголтой болох ажлыг зохион байгуулах

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ГАЗАР

Найрамдал хотхон, 3 дугаар баг,
Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42015
Утас/Факс: (976) 7054 3661,
Цахим шуудан: gobisumber@cfga.gov.mn,
Цахим хуудас: www.gobisumber.cfga.gov.mn

2024. 10. 25 № 271

танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аудитын тайлангийн төсөлтэй танилцав.
Санал байхгүй болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.УРАНГОО



Ахлах аудитор
Б. Анхтүвшин
Найрамдал хотхон
Сүмбэр сум
Баянгол нур

D:/Бичиг хэрэг/Blank/A-5

Анхтүвшин
7/25

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Шалгагдагч байгууллагаас тайлангийн төсөлд саналгүй гэж ирүүлсэн байна.